

**#1. ЗӨВЛӨМЖ**

**Түгээмэл тархацтай
ашигт малтмал
ашиглах тусгай
зөвшөөрлийг олгохдоо
тухайн талбай
байрших сумын
иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын
болон аймгийн
иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн
саналыг авч
шийдвэрлэж байх,
цаашид дахин алдаа,
зөрчил гаргахгүй
ажиллах**

ЗӨВЛӨМЖ

Баянхонгор аймгийн Засаг дарга 2018 онд Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг 3 аж ахуйн нэгжид олгосон. Үүнд:

-2018 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/598 дугаартай захирамжаар элс, хайрга, чулууны ордыг ашиглах зөвшөөрлийг “Өсөх Урам” ХХК;

-2018 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/635 дугаартай захирамжаар элс, хайрга, чулууны ордыг ашиглах зөвшөөрлийг “Шанхай Констракшн Групп” Компани;

-2018 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн А/639 дугаартай захирамжаар элс, хайрга, чулууны ордыг ашиглах зөвшөөрлийг “Монроуд” ХХК-д тус тус олгосон.

Эдгээр түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг олгохдоо Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 14.2-т заасан мэдэгдлийг хүлээн авмагц тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч ажлын 10 өдрийн дотор түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох, эсэх асуудлыг шийдвэрлэнэ” гэснийг зөрчжээ.



#2. ЗӨВЛӨМЖ

Газрын зориулалт өөр өөр дуудлага худалдаа бүрт байнга оролцдог, үнэ нэмж хэлдэггүй, өөрөөр хэлбэл оролцогчийн тоо нэмэх зорилготой оролцогчид байна. 2-3 оролцогч оролцоод нэг удаа 100'000 төгрөгөөр үнэ нэмж хэлээд газар авч байна. Эдгээр оролцогчид нь дуудлага худалдааны тэмдэглэлээс үзэхэд зохион байгуулалтай оролцож байгаа нь харагдаж байна. Газрын дуудлага худалдааг үр ашигтай, хэлбэр төдий бус, олон нийтийг тэнцвэртэй оролцуулж байх зохион байгуулалтын арга хэмжээг авах.

Жишээ нь:

1. Баянхонгор аймгийн Засаг даргын 2018 оны А/54 дүгээр захирамжаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын 34 дүгээр тогтоолоор Аймгийн газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөө болон 51 дүгээр тогтоолоор Газар зохион байгуулалтын нэмэлт төлөвлөгөөнд тусгагдаагүй Цахир баг 7-р баг төв захын зүүн талын 1035м² газрыг таксины зогсоолын зориулалтаар, “Үдшийн зах”-ын ард 1055 м² газрыг худалдаа үйлчилгээний зориулалтаар үнэ төлбөргүй “Түй долгио”ХХК-д эзэмшүүлсэн нь Газрын тухай хуулийн 33.1.1-д “энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан болон төсөвт байгууллагад зайлшгүй хэрэгцээтэй газрыг эзэмшүүлэх тухай шийдвэрийг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний дагуу тухайн шатны Засаг дарга гаргана”, мөн 33.1.2-т “энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ” гэж заасныг тус тус зөрчсөн нь хяналт шалгалтаар тогтоогдсон.
2. Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Номгон баг хуучнаар Зам ангийн зүүн талд байрлах “Хаш гоёо” ХХК нь 2012 оны 349 дүгээр захирамжаар 6500 м² газрыг бетон зуурмагийн үйлдвэрийн зориулалтаар эзэмшиж байсан. 2017 оны 03 дугаар сарын 22-ний өдрийн 17/10 албан тоотоор бетон зуурмагийн үйлдвэрийн орчны газрыг нэмж эзэмшүүлэх тухай хүсэлт ирүүлсний дагуу 2017 оын ГЗБ-ын төлөвлөгөөнд тусган аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 112 дугаар тогтоолын дагуу Аймгийн Засаг даргын 2018 оны А/03 захирамжаар 20964 м² газрыг 8.0 сая төгрөгөөр нэмж эзэмшүүлсэн байгаа нь Газрын тухай хуулийн 33.1.2 дэх заалт буюу “энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ” гэснийг зөрчсөн байна.



Нийт зарцуулсан төсвийн 18.6 хувь нь буюу 56.984.566 төгрөг нь Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1, 2.1.2 дэх хэсэгт заасан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалтад нийцэж байна. Мөн 25.6 хувь нь буюу 74.599.930 төгрөгийг дээрх журмын 2.1.3 дахь хэсэгт заасан арга хэмжээнд зарцуулагдсан байна гэж үзэж болохоор байна. Үүнээс бусад 168.915.456 төгрөг буюу 44.2 хувь нь зориулалтын бусаар зарцуулсан байна.

Сангийн сайдын 2012 оны Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.3 дугаар зүйлд “энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана” гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй буюу 2018 оны нөөц хөрөнгийн 91.9 хувийг зарцуулсан байна.

Мөн Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах тухай захирамж гаргахдаа Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцдэггүй байна.

#3. ЗӨВЛӨМЖ

Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, тэвчиж болох зардлыг бууруулах шаардлагатай байна. “Засаг Даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь хэсэгт заасан “Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлэх” гэсэн заалтыг зүй зохистой хэрэгжүүлж ажиллах.



Өргөдөл, гомдлын бүртгэлийг гараар хөтөлдөг, зарим хэсэгт бүртгэл нь дундаа тасарсан байсан. *Жишээ нь:* 303 дугаартай өргөдөл байхад дараагийнх нь 305-аас эхэлсэн байсан. Мөн хаяг, холбогдох утасны дугааргүй өргөдлүүд цөөн тоогоор хүлээн авсан байна.

Өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн аваад дараагийн шатны байгууллагад, байгууллагын дарга нарт цохсон цохолт нь байх боловч тухайн өргөдөл, гомдол яаж шийдэгдсэн эсэх нь тодорхой бус ихэнх хувийг эзэлж байсан. Цөөн хэдэн өргөдөл хэрхэн шийдвэрлэсэн шийдвэр нь тодорхой байсан. Өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэсэн байна.

Баянхонгор аймгийн удирдлагууд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 7 хоногт 1 удаа аймаг орон нутагт хийгдэж буй ажлуудын талаар мэдээлэл хийдэг ч өргөдөл, гомдлын талаар мэдээлдэггүй. Мөн цөөн тохиолдолд Цагдаагийн газар, Шүүхийн байгууллага руу шилжүүлэх өргөдөл, гомдлыг БСУГ-руу цохсон байсныг тодруулж холбогдох арга хэмжээ авч ажилласан.

Иймд:

1. Өргөдөл, гомдлын бүртгэл шийдвэрлэлтийн баримт материалын бүрдлийн эмх цэгцийг сайжруулж хяналтын хуудас хөтлөх
2. Иргэнд амаар болон харилцах утсаар өгсөн хариуг нэгдсэн бүртгэлтэй болгох
3. Холбогдох байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлсэн иргэдийн өргөдөл, хүсэлтийн хариуг заасан хугацаанд авч өргөдөлд хавсаргаж байх
4. Хүнд өвчин туссаны улмаас Засаг даргаас эмчилгээний төлбөр хүссэн өргөдөл их байна. Тусламж үзүүлэх шийдвэр гаргахдаа өргөдөл, өвчтөний эмнэлгийн түүх, эмчийн магадлагаа, эхоны зураг гэх мэт тухайн хүн өвдсөн нь үнэн болохыг баталсан баримтуудыг үндэслэж мөнгөн тусламж үзүүлэх нь зүйтэй байна.

Төрийн захиргааны салбар хариуцсан албан хаагчид салбарынхаа ажлыг бүрэн хариуцаж салбартай холбоотой дахин давтан гарч байгаа өргөдөл, гомдол, саналыг судлан зохих арга хэмжээ авч дахин гомдол санал гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллах. Тусламж хүссэн гомдлыг шийдвэрлэхдээ урьдчилан боловсруулсан арга хэмжээг авах, нөхцөл байдлыг судалсан материалаа өргөдөлтэй хавсаргах.

#4. ЗӨВЛӨМЖ

Өргөдөл, гомдлын бүртгэлийн дэвтэрт иргэний өргөдөл, гомдол бүрэн бүртгээгдсэн боловч шийдвэрлэлтийн дугаар, номер тэмдэглэгдээгүй байна. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан хариуг амаар, харилцах утсаар мэдээгдсэн бол энэ тухай бүртгэлд тэмдэглэнэ гэсэн заалтын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах



#5. ЗӨВЛӨМЖ

**Худалдан авах
ажиллагаанд
тендерийн баримт
бичгийн бүрдэл
хангалтгүй, шууд гэрээ
байгуулахдаа
захиалагчийн баталсан
техникийн
тодорхойлолтонд
заасан шаардлагыг
хангаагүй бараа,
бүтээгдэхүүн
нийлүүлэх, хүлээн авах
зэрэг зөрчил байна.
Иймд холбогдох хууль
тогтоомжийг
хэрэгжүүлж ажиллах.**

Үнэлгээний хорооноос шууд гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлсэн тохиолдолд хариуцсан мэргэжилтэн тухайн бараа материал, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн зах зээлийн үнийг судалж судалгааны материалыг болон аж ахуйн нэгжүүдээс үнийн саналыг авч шууд гэрээ байгуулах ажлыг ил тод зохион байгуулах, үнийн санал, үнийн судалгааг хийгээгүйн улмаас шууд гэрээ байгуулж худалдан авалтыг хийх үед зах зээлийн ханшаас хэт өндөр үнээр худалдан авалтыг зохион байгуулж захиалагч талаас гэмт хэргийн шинжтэй үйлдэл гаргасан үйлдэл илэрч байна.

Мөн тендерийн баримт бичгийн бүрдэл хангалтгүй, архивын нэгж болгоход эмх цэгцтэй Архивын тухай хуулийг чанд баримтлах, үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нь үнэлгээний хорооны гишүүдээр ашиг сонирхлын зөрчилгүй талаар болон үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдэгдлийг гаргаж байх шаардлагатай.

Шууд гэрээ байгуулахдаа захиалагчийн баталсан техникийн тодорхойлолтонд заасан шаардлагыг хангаагүй тээврийн хэрэгслийг худалдан авсан гэмт хэргийн шинжтэй үйлдлийг удаа дараа гаргасан зөрчилүүд илэрч байна. Иймд шууд гэрээ байгуулах ажлыг ил тод нээлттэй зохион байгуулах зайлшгүй шаардлагатай байна. Мөн худалдан авалтыг зохион байгуулахдаа орон нутагт тохиромжгүй, шатахуун зарцуулалт ихтэй тээврийн хэрэгслийг сонгон худалдан авсан үндэслэл байх тул худалдан авалтыг төлөвлөх ажиллагаанд зайлшгүй анхаарч ажиллах шаардлагатай байна. Энэ маягаар үр ашиггүй, эвдрэл, зардал ихтэй тээврийн хэрэгсэл худалдан авсан нь цаашид дахин тээврийн хэрэгслийг худалдан авах нөхцлийг бүрдүүлж байна.

Дээрхээс гадна:

1. Суманд тендер зохион байгуулах ажиллагаа бүрэн цахимжаагүй, цахимаар зарлах нөхцөл муутай, зарлалын самбарт зарыг байршуулж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчиж байна. Тус хуулийг зөрчсөн тохиолдолд Эрүүгийн хууль, Зөрчлийн хуулиар хариуцлага тооцохоор хуульчилсан тул гэмт хэрэгт холбогдон шалгагдах магадлалтай тул захиалагч, үнэлгээний хорооны гишүүд үүнээс урьдчилан сэргийлж хуулийн дагуу тендерийг зохион байгуулж ажиллах шаардлагатай.
2. Мөн өмнө нь бусад сумдад, гарч байсан Тендерийн баримт бичгийг захиалагчаар батлуулаагүй зөрчлүүд удаа дараа гарч байгаа нь удирдлага зохион байгуулалт, сургалт муу байна. Иймд аймгийн ЗДТГ-аас сумдад худалдан авах ажиллагааг зохион байгуулах талаар сургалтуудыг үе шаттай явуулах шаардлагатай.
3. Худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэж буй ажил үйлчилгээнд захиалагчийн хяналтыг сайжруулаагүйгээс гэрээний хугацаандаа ажил гүйцэтгээгүй, мөн гэрээнд хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд алдангийг бүрэн тооцож гэрээний 2 талын оролцогчдын хариуцлагыг дээшлүүлэх.
4. Баянхонгор аймгийн Жинст суманд үнэлгээний хорооны байнгын бус ажиллагаатай байхыг хуульчилсан байхад 1 үнэлгээний хороо 2 тендерийг зохион байгуулсан, Убулангийн багийн мэдээллийн төвийг шинэчлэн барих ажилд гэрээ байгуулахдаа хугацаагүй гэрээ байгуулсан нь эрсдэл үүсгэж байна.



Захиргааны ерөнхий хуулийн шаардлагад нийцүүлэн “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг шинэчлэн боловсруулж, Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан бөгөөд уг журам нь захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 4036 дугаартай бүртгэгдсэн (журмыг <https://www.legalinfo.mn/law/details/13778?lawid=13778> -ээс татаж үзэх).

Журмын 4.1-т “Албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан талаарх мэдээллийг холбогдох этгээдэд хүргэсэн болон нийтэд мэдээлсэн өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор журмын 2.1, 3.1-т заасан мэдээллийг тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэр (хуулбар)-ын хамт эсхүл холбогдох мэдээллийг цахим хэлбэрээр Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.” гэж заасан.

#6. ЗӨВЛӨМЖ

Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг хэрэгжүүлэх, журмын 4.1-д заасан хугацаанд холбогдох мэдээллийг ирүүлж хэвших.



#7. ЗӨВЛӨМЖ

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахгүйгээр томилох, эсхүл томилсны дараа хянуулдаг зөрчлийг таслан зогсоох талаар орон нутгийн хэмжээнд зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.

2017 онд ажилласан 3 дугаар багаас **Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахгүй томилдог, томилсны дараа хянуулдаг зөрчлийг таслан зогсоох** зөвлөмжийг хүргүүлсэн байх боловч Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5, 23.6 дахь хэсэгт заасныг зөрчиж нэр дэвшигчийн ХАСУМ-ийг хянуулалгүй томилох, томилсны дараа хянуулдаг зөрчил аймгийн Засаг даргын тамгын газар гараагүй байх боловч сумдад дээрх зөрчил гарсаар байна.

Тухайлбал, Баянхонгор аймгийн зарим байгууллагад холбогдох хяналт шалгалтыг явуулахад 2017, 2018 онд 5 этгээдийг тухайн албан тушаалд томилсны дараа хянуулсан, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 5 этгээдийн ХАСУМ-ийг хянуулаагүй томилсон байна (Хавсралт 1, 2). Нэр дэвшигчийн ХАСУМ-ийг хянуулалгүйгээр албан тушаалд томилсон тохиолдолд тухайн иргэн Авлигатай тэмцэх газрын цахим бүртгэлийн системд нэвтэрч албан тушаалд томилогдсноос хойш 30 хоногийн дотор ХАСХОМ гаргах боломжгүй тул түүнээс үүдэн гарах үр дагаврыг анхаарч ажиллах шаардлагатай.



#8. ЗӨВЛӨМЖ

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасны дагуу мэдүүлэг гаргагч албан тушаалтан хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн албан тушаалыг хашиж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргах үүрэгтэй. Уг үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.1-д зааснаар “хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг энэ хуулийн 23.3-т заасан хугацаанаас хожимдуулж гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол сануулах”, мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т зааснаар “...хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг энэ хуулийн 23.3-т заасан хугацаанаас удаа дараа хожимдуулж гаргасан бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах”, Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8.1-д зааснаар “...заасан хугацаанаас хожимдуулсан нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол сануулах” шийтгэлийг тус тус ногдуулах зохицуулалтыг мөрдөж ажиллах шаардлагатай.

2017 онд ажилласан 3 дугаар багаас хүргүүлсэн зөвлөмжид туссан байх боловч тус аймгийн хэмжээд 2017 онд 3 албан тушаалтан томилогдсоноос хойш 30 хоногийн дотор ХАСХОМ гаргаагүй хугацаа хоцроож мэдүүлсэн, 3 албан тушаалтан мэдүүлгээ хуулийн хугацаанд гаргаагүй, 2018 онд 13 албан хаагч тухайн албан тушаалд томилогдсоноос хойш 30 хоногийн дотор ХАСХОМ гаргаагүй хугацаа хоцроож мэдүүлсэн, 1 албан тушаалтан мэдүүлгээ хуулийн хугацаанд гаргаагүй зөрчилтэй байна. (Хавсралт 3).

Нийтийн албан тушаалд томилогдсоноос хойш хуульд заасан хугацаанд Хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын мэдүүлэг(ХАСХОМ) гаргаж хэвшүүлэх, хугацаандаа гаргаагүй албан тушаалтанд хариуцлага тооцож байх, түүнд тавих хяналтыг сайжруулах.

**#9. ЗӨВЛӨМЖ**

Иргэнийг хуульд заасан болзол, журмын дагуу төрийн албанд орох адил тэгш боломжоор хангах, төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөхдөө хууль тогтоомжийн дагуу мэргэшлийн шалгалт өгөөгүй, төрийн албаны нөөцөд бүртгэгдээгүй иргэнийг томилдог зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахаас урьдчилан сэргийлэх, шинээр болон дэвшүүлэн томилохдоо мерит зарчмыг удирдлага болгон ажиллах.

Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөхдөө хууль тогтоомжийн дагуу төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалт, удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтгүйгээр шууд томилсон нь Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 /хуучнаар/ 43 дугаар зүйл /шинэ хууль/ болон Улсын Их Хурлын 2003 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ыг тус тус зөрчсөн байна.

Тухайлбал, төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөж шинээр болон сэлгэн томилсон байдлыг хянан үзэхэд төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт болон удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалт, Төрийн албаны салбар зөвлөлийн дүгнэлтгүйгээр 2017-2018 онд нийт 21 албан тушаалтан томилогдсон байна (Хавсралт 4).



Говь-Алтай аймгийн хэмжээнд 2017-2018 онд 7 хүн шүүхийн шийдвэрийн дагуу эргэн томилогдон нөхөн олговорт нийт **37.842.897** төгрөгийн тэтгэмж олгохоор шүүхээс шийдвэрлэсэн байна. (Хавсралт 5).

Ажлаас үндэслэлгүй халагдсан, чөлөөлөгдсөн этгээдийг шүүхийн шийдвэрийн дагуу ажилд нь эгүүлэн томилж, ажилгүй байх хугацааны цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл зэргийг захиргааны байгууллагаас нөхөн төлж төсвийг үр дүнгүй зарцуулж, хохирол учруулж байгаа учраас хууль бус шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар хохирлыг буцааж төлүүлж барагдуулах талаар арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай байна.

Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т “иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага гэм буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлнэ. Хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна”, мөн Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д “...гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй” гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулах талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.

#10. ЗӨВЛӨМЖ

Төрийн албан хаагчдыг зөвхөн хуульд заасан үндэслэлээр ажлаас чөлөөлөх, үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсний улмаас төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэх, хууль бус шийдвэр гаргасан тохиолдолд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх асуудлыг Иргэний хууль, Захиргааны ерөнхий хуулийн дагуу шийдвэрлүүлж байх.



Тус аймагт “Баянхонгор Эрчим хүч” ХХК, “Чандмань Баянхонгор” ХХК, “Баянхонгор Тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ, “Цэвэр хот” ХХК, “Баянхонгор хайрхан фарм” ХХК, “Баянхонгор Нью майнинг” ОНӨҮГ, “Баянхонгор Үйлдвэржилт” ХХК гэсэн 8 орон нутгийн өмчит хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байна. Хавсралтаар

ТУЗ-ийн гишүүнээр улс төрийн албан тушаалтан буюу ИТХ-ын төлөөлөгчийг томилон ажиллуулж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21-р зүйлийн 5 дахь хэсэгт “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд төрийн захиргааны албан хаагч” байх гэж заасан шаардлагыг зөрчсөн.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлд заасан ИТХ-ын бүрэн эрхэд хамаарах “орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах”, “иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх” чиг үүрэг хангалтгүй. Үйл ажиллагааны үр дүн жилийн эцсийн тайлан ИТХ-д тайлагнасан, хэлэлцсэн баримт материал байхгүй байсан.

Үйл ажиллагааны үр дүнг дүгнэсэн гэх баримт нь зөвхөн ТУЗ-өөс гүйцэтгэх захиралтай байгуулсан Хөлсөөр ажиллах гэрээг дүгнэсэн, эсвэл аймгийн Орон нутгийн өмчийн газраас Эд хөрөнгийн ашиглалтын гэрээг дүгнэсэн материалууд байна.

ИТХ, Засаг даргаас эдгээр ОНӨҮГ-удын үйл ажиллагааны үр дүн, эдийн засгийн үр ашгийг хэлэлцэж хяналт шинжилгээ үнэлгээ хийхгүй байгаа нь төрийн өмчийг үнэгүйдүүлэх, төсвийн хөрөнгийн үр ашиггүй зардлыг нэмэгдүүлэх, орон нутгийн төсөвт дарамт учруулах нөхцөл байдлыг үүсгэж болзошгүй. Ажлын үр дүн, тайланд дотоод хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, санхүүгийн хувьд алдагдалтай ажиллаж байгаа шалтгаан нөхцлийг тодорхойлж, ИТХ-аар хэлэлцэх шаардлагатай.

“Баянхонгор Үйлдвэржилт” ХХК Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор 2017 онд 14 аж ахуйн нэгжийн төсөлд 560,0 сая төг-н санхүүжилт олгосоноос;

- “Баялаг номгон” ХХК-ийн сав баглаа боодол үйлдвэрлэх зориулалтаар авсан 70,0 сая төг-с хэвлэлийн машин, тоног төхөөрөмж авсан боловч үйл ажиллагаа эхлээгүй,
- “Жимекс” ХХК-ийн цагаан будаа тариалах зориулалтаар авсан 95,0 сая төг үйл ажиллагаа явуулаагүй,
- Иргэн Т.Отгонсүрэн телевиз засвар зориулалтаар авсан 5,0 сая төг үйл ажиллагаа явуулаагүй,
- “Номгон хүнс” ХХК-ийн гоймон үйлдвэрлэх зориулалтаар авсан 50,0 сая төг үйл ажиллагаа явуулаагүй зөрчилтэй.

2018 онд 18 аж ахуйн нэгжийн төсөлд 450,0 сая төг-н санхүүжилт шийдвэрлэсэнээс 380,0 сая төг-н санхүүжилт олгогдсон. Төслийн үр дүнг дүгнэх хугацаа болоогүй, гүйцэтгэлийн хяналтаар үйл ажиллагаа эхлээгүй төсөл байхгүй байна.

Төслийн хэрэгцээ шаардлага, зах зээлийн судалгаа, эдийн засгийн үндэслэл зэргийг сайтар судлаж шийдвэрлэх, зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байгаа байдалд тогтмол хяналтыг сайжруулж, тайлагнаж байх, зориулалтын дагуу ашиглаагүй, үйл ажиллагаа явуулаагүй төслийг гэрээ цуцлах арга хэмжээ авах, хуулийн байгууллагад шилжүүлж, хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авах нь зүйтэй.

#11. ЗӨВЛӨМЖ

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийг байгуулахдаа хэрэгцээ, шаардлага, эдийн засгийн үр ашгийг сайтар тооцох, Үр ашиггүй ажиллаж, орон нутгийн төсвөөс татаас авч буй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, холбогдох арга хэмжээг авах